

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2021.12.28

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	АГГ-2021/15-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага:	Төсвийн ерөнхийлөн захирагчид
Аудитын нэр:	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын гуравдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор Б.Болормаа Аудитор Ж.Оюунтуяа Ш.Наранбаатар Ч.Баярмаа

Хоёр. Аудитын үр дүн:

Аудитын зорилт: “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн болно.

Аудитын хамарсан хүрээ: Аудитад ЗГХЭГ, Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааг хамруулав.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖЛИЙН ПРАКТИКИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦЭХГҮЙ БАЙНА

Улсын салбарын дотоод аудитын эрх зүйн орчин олон улсын стандартад нийцэхгүй байна

УИХ-ын 2011 онд баталсан Төсвийн тухай хуульд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагчдын дотоод аудитыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж зааснаар төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцооны эхлэл тавигдсан байна.

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д ТЕЗ, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зохион байгуулалт, дотоод аудиторын эрх үүргийг ДАМПОУС-д нийцүүлэн тодорхойлжээ.

“Дотоод аудитын дүрэм”-ийг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг нэмж оруулсан нь олон улсын стандартын зарчимтай нийцэхгүй болсон.

Дотоод аудитын талаар бие даасан хууль байхгүй байгаа тул тодорхойлолт болон эрх мэдэл, үүрэг хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтгүй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.8-д *“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоод аудитын нэгжийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангана”* гэж заасны дагуу төрийн байгууллагуудын Дотоод аудитын нэгжийг стандарт, арга зүйн удирдлагаар хангах, улсын салбарын дотоод аудитыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, дотоод аудитын үр нөлөөтэй тогтолцоог бий болгох, тэдний үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх үүргийг хүлээсэн байна.

Төсвийн тухай хуулийн нэр томъёоны бүлэгт дотоод аудитыг “төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагаа” гэж тодорхойлсон нь олон улсын стандартад заасан тодорхойлолт, зарчимд нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоог төвлөрсөн бус загвартай байхаар заасан боловч тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь *“Төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах”* бүрэн эрхтэй гэж тодорхойлсон нь бусад төрлийн дотоод аудитыг арга зүйн удирдлагаар хангах субъектийг хуульд тусгаагүй байна.

Төсвийн тухай хуульд улсын салбарын дотоод аудитын тогтолцоог төвлөрсөн болон төвлөрсөн бус хэлбэрийг хослуулсан байхаар тусгасан нь чиг үүрэг давхардах, үр нөлөө буурах, нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал:

- *Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4-д “Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.7-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудиторт санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрх олгож болно” гэж заасан нь хоорондоо зөрүүтэй байна.*

Дотоод аудиторт санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх олгож байгаа нь олон улсын стандартын үндсэн зарчимд нийцэхгүй байна.

Олон улсын мэргэжлийн практикийн хүрээнд дотоод аудитыг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлөх үйлчилгээ гэж тодорхойлсон нь Дотоод аудитын нэгжийн хараат бус байдлыг хангасан байна.

Дотоод аудитын эрх зүйн орчныг сайжруулж, тогтолцоог оновчтой болгон, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-д *“дотоод аудитад ... зөвхөн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”* гэж заасныг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний заавал дагаж мөрдөх шаардлага, дотоод аудитын зорилго, тодорхойлолт, үндсэн зарчим, стандартад нийцүүлэх шаардлагатай байна.

Зарим улсын дотоод аудитын нэгжийн бүтэц, сайн туршлагаас дурдвал

Дотоод аудиторчуудын Олон улсын институтээс тодорхойлсны дагуу Засгийн газар нь улс төрийн шийдвэр, санхүү, төсөв болон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт зэргээс шалтгаалж, дотоод аудитын нэгжийг төвлөрсөн эсвэл төвлөрсөн бус байдлаар зохион байгуулдаг байна. */Нэгдсэн тайлангийн 1.15-1.19/*

Төвлөрсөн дотоод аудитын нэгж байгуулсан олон улсын сайн туршлагаас дурдвал:

Австралийн Дотоод аудиторчуудын институт нь 1948 онд байгуулагдсан бөгөөд улсын салбарын аудитын дээд байгууллага буюу Австралийн Үндэсний аудитын байгууллага нь улсын хэмжээнд үндэсний аудиторын үүргийг гүйцэтгэдэг байна. */Нэгдсэн тайлангийн 1.21-1.23/*

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо төлөвшөөгүй, стандартын шаардлагыг хангахгүй байна

Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний Гүйцэтгэлийн стандарт “2010-Төлөвлөлт”-д *“Төлөвлөлт хэсэгт аудитын гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэн тэргүүнд анхаарах асуудлыг тодорхойлохын тулд өөрийн байгууллагын зорилготой уялдсан эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргана”*, Дотоод аудитын дүрмийн 7.1¹-д гэж заасныг үндэслэн Сангийн сайдын 2014 оны 11 дүгээр тушаалаар “Улсын салбарын дотоод аудитыг 2014-2016 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг

¹ Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална”.

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан боловч төрийн байгууллагуудын Дотоод аудитын нэгжүүд хэрэгжүүлээгүй, хугацаа дууссан, дараагийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

Улсын салбарын Дотоод аудитын тогтолцоо нь төлөвшөөгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт, мэргэжлийн бус хүний нөөц, улс төрийн болон хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалж байна.

Олон улсын стандартад зааснаар дотоод аудитын үйл ажиллагааг “дотоод аудитын нэгж” хэрэгжүүлнэ. Нэгж нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн “Дотоод аудитын дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба өөрийн онцлогт тохирсон нэгжийн дүрэмтэй байж болно гэж заажээ.

Дотоод аудитын дүрэм нь тухайн нэгжийн зорилго, ажлын цар хүрээ, эрх, үүргийг тодорхойлсон байна. Үүнд:

- *Дотоод аудитын нэгж нь тухайн байгууллага зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд ямар цар хүрээнд, ямар арга замаар үйл ажиллагааг явуулах;*
- *Байгууллагын дотоод аудитын нэгж ямар чиг үүрэгтэй ажиллах, ажлын үр дүнгээ тайлагнах;*
- *Аудитыг гүйцэтгэхэд байгууллагын мэдээлэл, биет хөрөнгийг ашиглах, холбогдох ажилтантай хэрхэн харилцах зэргийг дурдана.*

Хэдийгээр олон улсын стандартад дотоод аудитын дүрэмтэй байж болно гэж заасны дагуу Төрийн байгууллагууд Засгийн газрын тогтоолоор баталсан дотоод аудитын дүрмийг мөрдөж байгаа боловч тус дүрмийг олон улсын стандартад нийцүүлэн дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, ажлын цар хүрээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Дотоод аудитын дүрэмд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. /Нэгдсэн тайлангийн 1.29-1.33/

Дотоод аудитын нэгжийн хүний нөөц тогтворгүй, зохион байгуулалт болон төсөв, санхүүгийн хараат бус байдал хангагдаагүй байна

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3², 10 дугаар зүйлийн 10.2³ дэх хэсгийг үндэслэн тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дотоод аудитын нэгжийн бүтэц үйл ажиллагааны стратегийг баталдаг байна.

Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах зэрэг ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэдэг нь Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлж байна. /Нэгдсэн тайлангийн 1.36-1.47/

БҮЛЭГ 2. ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМД ТУСГАСАН БОЛОВЧ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Төрийн байгууллагуудын Дотоод аудитын нэгжүүд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байгаа нь олон улсын стандартад нийцэхгүй байна

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2⁴-т заасныг үндэслэн Сангийн сайдын 2014 оны 11 дүгээр тушаалаар “Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг баталж, дотоод аудитын эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хүргэх стратегийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. /Нэгдсэн тайлангийн 2.2-2.3/

Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги нь дотоод аудитын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэргэшсэн дотоод аудиторыг бэлтгэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дотоод аудитын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд үзүүлэх, дотоод аудитын чанарын баталгаажуулалтыг нэвтрүүлэх, дотоод аудитын үр дүнг олон нийтэд таниулан сурталчлахад чухал баримт бичиг болсон боловч дээрх зорилтууд бүрэн хэрэгжээгүй, үр дүнг Дотоод аудитын хороонд танилцуулаагүй байна.

Дотоод аудитын нэгж нь байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэн, байнгын сайжруулалтыг санал болгох замаар удирдлагын шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй байна.

Засгийн газрын 2009 оны “Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай” 46 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 85 дугаар тушаалаар Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрыг 10 албан хаагчийн орон тоотой байгуулжээ.

Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газар нь 2013 онд Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар болон өөрчлөгдсөн бөгөөд Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас шилжүүлж, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын орон тоо нэмэгдэн, дотроо Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний болон Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэстэй болсон байна.

Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрыг 2016 онд Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нэртэй, 19 албан хаагчийн орон тоотой болгон өөрчилж, төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн ажиллажээ. /Нэгдсэн тайлангийн 2.8-2.9/

Дотоод аудитын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд үнэлгээ өгөх чиглэлийн хүрээнд:

- Дотоод аудитын дүрмийн 7.9-д зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь хагас, бүтэн жилийн тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдөр болон тухайн жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ” гэж заажээ.

Сангийн яамнаас төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны тайланг хүлээн авдаг боловч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгдөггүй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 1.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллахтай холбогдох харилцааг зохицуулна” гэж заасан нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны чиг үүргийн ялгаа, онцлогийг тусгааргүй, ДАМПОУС-д нийцэхгүй байна.

Сангийн яам дотоод аудитын чиг үүрэг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд улсын салбарын Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг ДАМПОУС-д нийцүүлэх ажлыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна. Үүнд:

- Дотоод аудитын урт болон дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлээгүй;
- Улсын салбарын дотоод аудитын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй;
- Дотоод аудитын нэгжийн хүний нөөц /дотоод аудитор/-ийг сургаж, мэргэшүүлэх, тогтвортой хараат бусаар ажиллах эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлээгүй;
- Дотоод аудитын үйл ажиллагаа, үүрэг зорилго, зарчим, арга зүйн талаар Төсвийн ерөнхийлөн захирагчид, шийдвэр гаргагчдыг сургалт, мэдээллээр хангах талаар санаачилгатай ажиллаагүй байна.

Дотоод аудитын нэгжүүд нь ихэвчлэн санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, дотоод аудитыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлэхгүй байгаа нь ТЕЗ-д дотоод аудитын үр нөлөө, ач холбогдлын талаар нэгдсэн ойлголт байхгүй мөн зарим төрийн байгууллагын аудиторчуудын мэргэжлийн чадвар хангалтгүй, хүний нөөцийн тогтворгүй байдал зэргээс хамааралтай байна.

Аймгуудын Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд Санхүүгийн хяналт болон дотоод аудитыг дараах байдалтай хийсэн байна. /Нэгдсэн тайлангийн 2.15-2.19/

Төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхойгүй байна

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллага өөрт учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх

үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, хэрэв тийм нэгж байхгүй бол энэхүү үүргийг төрийн аудитын байгууллага хариуцахаар заасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас Захиргааны ерөнхий хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд 2018-2020 онд 2,829.8 сая төгрөгийн 43 акт, 142 албан шаардлагыг холбогдох газарт хүргүүлснээс 576.4 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна. /Нэгдсэн тайлангийн 2.22-2.25/

Дотоод аудитын үр дүнг нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй байна

Төсвийн ерөнхийлөн захирагчдад дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг бүртгэх, биелэлтэд хяналт тавих, үр дүнг тооцох, үнэлэх нэгдсэн мэдээллийн сан байхгүй байгаа нь эрх зүйн зохицуулалтаас шууд хамаарч байна.

Дотоод аудитын тайлан болон өгсөн зөвлөмж, түүний биелэлтийг бүртгэх, хянах зорилгоор мэдээллийн санг үүсгэх нь тухайн байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, ижил төстэй зөрчил давтан гарахгүй байх, улмаар байгууллагын үйл ажиллагаанд эерэг үр дүн гарч байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болохоор байна.

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, Дотоод аудитын нэгжээс ирүүлсэн тайланд үнэлгээ хийгээгүй байна

Дотоод аудитын дүрмийн 9⁵-д Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллахаар заасан боловч тус заалтын хэрэгжилт хангалттай биш байна.

Төрийн байгууллагуудын Дотоод аудитын нэгж тухайн жилд гүйцэтгэсэн дотоод аудитын тайланг Дотоод аудитын дүрмийн 7.9⁶-д заасан хугацаанд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэст хүргүүлж байгаа боловч УИХ болон Засгийн газрын харьяа байгууллагууд ирүүлдэггүй байна. /Нэгдсэн тайлангийн 2.30-2.33/

Монголбанк нь Дотоод аудитын дүрэм, стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж ажилласан байна

Монголбанкны хувьд ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн А/266 дугаар тушаалын 5.2-т “5 жилд 1 удаа хөндлөнгийн чанарын үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу Олон улсын зөвлөх Роб Корнеллисэ 2019 оны 9 дүгээр сард Монголбанкинд ирж ажилласан бөгөөд ажлын даалгаврын дагуу дотоод аудитын газрын үйл ажиллагаанд хөндлөнгийн чанарын үнэлгээ хийсэн тайланг 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдөр танилцуулсан нь сайшаалтай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Дотоод аудит нь байгууллагын эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөг үнэлж сайжруулах арга хандлагыг нэвтрүүлэх замаар зорилтуудаа биелүүлэхэд нь байгууллагад туслах, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйлчилгээг үзүүлэхгүй, зөвхөн санхүүгийн хяналт шалгалтаар хязгаарлагдаж байгаа нь “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-д нийцэхгүй байна;
- Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр ... дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж дотоод аудитын тогтолцоог төвлөрсөн бус загвартай байхаар заасан боловч тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж төвлөрсөн загвартай байхаар заасан нь хоорондоо уялдахгүй байна;
- Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь “Төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах” бүрэн эрхтэй гэж тодорхойлсон боловч бусад төрлийн дотоод аудитыг арга зүйн удирдлагаар хангах субъектийг хуульд тодорхой тусгаагүй байна;

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа төлөвшөөгүй, аудитын тайланд үнэлгээ хийж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтгүй байна;
- Дотоод аудитын нэгжийн зарим дотоод аудиторуд хууль, дүрэмд заасан мэргэжлийн шаардлага хангахгүй, тогтворгүй ажиллаж байгаагаас дотоод аудитын төлөвшил, чанарт сөргөөр нөлөөлж байна;
- УИХ-д үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагууд Дотоод аудитын нэгжийн тайланг Сангийн яаманд тайлагнаж байх эрх зүйн зохицуулалт оновчгүй байна;
- Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлын талаарх холбогдох байгууллагуудын дүн мэдээлэл зөрүүтэй, нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй, Захиргааны ерөнхий хуулиар Дотоод аудитын нэгжид ногдуулсан чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

УИХ-д толилуулах нь:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцүүлэн бүтэц зохион байгуулалтын, үйл ажиллагааны, санхүүгийн болон хүний нөөцийн хараат бус байдлыг хангасан зохистой эрх зүйн орчин бий болгох;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

- Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын нэгжийг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцүүлэн нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;
- Захиргааны ерөнхий хуулиар албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой дотоод аудитын нэгжид ногдуулсан чиг үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;
- Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Төрийн албаны зөвлөл зэрэг төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн сантай болгох;

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжийг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцүүлэн мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг дэмжих, санхүүгийн хяналт шалгалтаар хязгаарлахгүй байх, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Дотоод аудитын нэгжийн хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэх.